



ХӨДӨЛМӨР ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

БҮРЭН ХАРААГҮЙ, ХЭЛГҮЙ, ДҮЛИЙ ОДОЙ ИРГЭН БОЛОН БАЙНГЫН АСАРГАА ШААРДЛАГАТАЙ ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАРАА АЛДСАН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНД ОРОН СУУЦНЫ ТӨЛӨХӨД, ХЭРЭВ НИЙТИЙН ХАЛААЛТГҮЙ СУУЦ, ГЭРТ АМЬДАРДАГ БОЛ ТҮЛШ ХУДАЛДАН АВАХАД ЖИЛД НЭГ УДАА МӨНГӨН ТУСЛАМЖ ОЛГОХ

- Бүрэн хараагүй гэдэгт харааны бэрхшээлийн улмаас хөдөлмөрийн чадвараа 70 ба түүнээс дээш хувиар алдсан иргэнийг хамруулах ба нэг өрхөд амьдарч байгаа 18 насанд хүрсэн бүрэн хараагүй иргэдэд тус бүрт нь тусламжийг олгоно.

- Байнгын асаргаа шаардлагатай гэдэгт эдгэшгүй хүнд өвчний болон удаан хугацаагаар эмчлэгдэх өвчний улмаас хооллох, хувцаслах, бие засах зэрэг өдөр тутмын үйлдлээ бие даан гүйцэтгэх чадваргүй болж хэвтрийн дэглэмд орж байнгын асаргаа шаардлагатай иргэнийг хэлэх ба уг иргэнд хөнгөлөлтийг олгоно. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд орон сууцны хөлс төлөх, түлш худалдан авахад олгох тусламжийг уг заалтанд хамаарах хүүхдэд нэгэн адил олгоно.

Дараах материалыг бүрдүүлнэ

- Өргөдөл
- Иргэний үнэмлэх, хуулбарын хамт
- Аймаг, дүүргийн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр
- Иргэнийг байнга асрах, эмнэлэгийн хяналтанд байлгах, шаардлагатай болохыг тогтоосон сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч, их эмч, аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын тодорхойлолт
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэх, хуулбарын хамт

Төрөлжсөн асрамжийн газарт тэжээн тэтгэх хүүхэд, төрөл, садангүй, бие даан амьдрах чадваргүй ганц бие, эсхүл тэжээн тэтгэх үүрэгтэй этгээд

нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх чадваргүй болох нь тогтоогдсон бөгөөд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах боломжгүй ахмад настан, мэргэжлийн үйлчилгээ, тусгай нөхцөл шаардагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүнд нөхцөлд байгаа, эсхүл байнгын асрамжид байдаг хөгжлийн бэрхшээлтэй 16 хүртэлх насны хүүхэд, гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийг хүлээн авна.

ТӨРӨЛЖСӨН АСРАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ НЬ ДАРААХ ТӨРӨЛТЭЙ БАЙНА. ҮҮНД:

1. Ахмад настны асрамжийн үйлчилгээ
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асрамжийн үйлчилгээ
3. Хүнд нөхцөлд байгаа 18 хүртэлх насны хүүхдийн асрамжийн үйлчилгээ
4. Гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийн асрамжийн үйлчилгээ

ТӨРӨЛЖСӨН АСРАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ДАРААХ ИРГЭН ХАМРАГДАНА.

1. Тэжээн тэтгэх хүүхэдгүй, бие даан амьдрах чадваргүй ганц бие, эсхүл тэжээн тэтгэх хүүхэд нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэйн улмаас дэмжлэг, туслалцаа үзүүлэх чадваргүй болох нь тогтоогдсон бөгөөд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах боломжгүй ахмад настан.

2. Мэргэжлийн үйлчилгээ, тусгай нөхцөл шаардагдсан болон тэжээн тэтгэх хүүхэдгүй, бие даан амьдрах чадваргүй ганц бие хөгжлийн бэрхшээлтэй иргэн.

3. Хүнд нөхцөлд байгаа, Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон байнгын асрамжид байдаг хөгжлийн бэрхшээлтэй 18 хүртэлх насны хүүхэд.

4. Улсын зардлаар төрөлжсөн асрамжийн газар асрамжлан өсгөхийг эцэг, эх нь зөвшөөрсөн дөрөв хүртэлх насны гурав ба түүнээс дээш ихэр хүүхэд.

Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр авагч ахмад настан, 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэний тогтоогдсон тэтгэврийнх нь 70

хувийг асруулж байгаа иргэнд, 30 хувийг тухайн асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагад нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу олгоно.

ТӨРӨЛЖСӨН АСРАМЖИЙН ГАЗАРТ АСРУУЛАХ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ ДАРААХ БИЧИГ БАРИМТЫГ БҮРДҮҮЛСЭН БАЙНА.

- Үйлчлүүлэгчээс асрамжийн газарт үйлчлүүлэхийг хүссэн өргөдөл;
- Сум, хорооны Засаг даргын тодорхойлолт;
- Үйлчлүүлэгчийн иргэний үнэмлэх;
- Үйлчлүүлэгчийн хувийн мэдээллийг багтаасан анкет;
- Тэтгэврийн дэвтэр болон нийгмийн халамжийн бусад үйлчилгээнд хамрагддаг болохыг нотлох бичиг баримт;
- Эрүүл мэндийн дэвтэр;
- Сум, хорооны өрхийн эмч болон аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийн эрүүл мэндийн үнэлгээний хуудас; / арьс өнгө, сүрьеэ, сэтгэл мэдрэл, архинд донтох өвчингүй байх /
- Хурц, архаг халдварт өвчингүй гэдгийг баталсан лабораторийн шинжилгээнүүд дүгнэлтийн хамт;
- Сум, хорооны нийгмийн ажилтны хийсэн нөхцөл байдлын үнэлгээний хуудас;
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар болон аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн албан тоот;
- Аймаг, дүүргийн Засаг даргын захирамж;
- Цээж зураг 2-4 хувь.
- Асруулагчийн үр хүүхэд, ах дүү, төрөл төрөгсөдгүй болохыг нотлох Улсын бүртгэлийн архивын лавлагаа

Асрамжийн газарт явуулахаар шийдвэрлэсэн иргэнийг тухайн аймаг, дүүрэг, сум, хорооны Засаг даргын Тамгын газар өөрийн зардлаар болон сум, хорооны нийгмийн ажилтан асрамжийн газарт хүргэж өгнө.

Асрамжид явуулахаар шийдвэрлэсэн иргэн нь хурц халдварт өвчтэй тохиолдолд эмчлүүлж эдгэрүүлсний дараа, нарийн мэргэжлийн эмчийн зөвшөөрлөөр энэхүү журмын 2.4, 2.5- д заасны дагуу хүлээн авна.

Асрамжийн газрын үйлчлүүлэгчийн үнэт зүйлийг тэдгээрийн хүсэлтээр тусгай жагсаалтаар хүлээн авч хадгалж болох бөгөөд жагсаалтын нэг хувийг эзэнд нь өгнө.

Асрамжийн газарт үйлчлүүлэхээр хүсэлт гаргасан үйлчлүүлэгчийг харьяа сум, хорооны нийгмийн ажилтны бусад байгууллагуудтай хамтран хийсэн нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан "Амьжиргааг дэмжих зөвлөл"-ийн шийдвэр, аймаг, дүүргийн Засаг даргын захирамж болон бусад дагалдах хувийн хэргийн хамт асрамжийн газрын нийгмийн ажилтан, эрүүл мэндийн ажилтан нар хүлээн авна.

ЭХ, ОЛОН ХҮҮХЭДТЭЙ ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭХ, ЭЦЭГТ ОЛГОХ ТЭТГЭМЖ

“Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль”-ийн 5 дугаар зүйлийн 5.1-д дараах тэтгэмжүүдийг олгохоор зохицуулсан. Үүнд:

- Жирэмсний таван сартайгаас эхлэн хүүхэд төрүүлэх хүртэлх хугацаанд эх сар бүр тэтгэмж авах эрхтэй.
- Төрүүлсэн 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх сар бүр хүүхэд асарсны тэтгэмж авах эрхтэй.
- Дөрөв хүртэлх насны ихэр хүүхэд төрүүлсэн эх нэг удаа тэтгэмж авах эрхтэй.
- 0-18 хүртэлх насны гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэг улирал бүр тэтгэмж авах эрхтэй.

ЖИРЭМСЭН ЭХИЙН ТЭТГЭМЖ:

Эхэд жирэмсний 5 сартайгаас төрөх хүртэл хугацаанд **Засгийн газраас тогтоосон хэмжээгээр** сар бүр 40,000 төгрөгийн тэтгэмжийг олгоно.

Жирэмсэн эхийн тэтгэмж авч байсан иргэн хүүхэд төрөнгүүт 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж авах хүсэлтээ сум, хорооны нийгмийн ажилтанд гаргана.

Жирэмсэн эхийн тэтгэмжид хамрагдах иргэн дараах бичиг баримтыг бүрдүүлэн сум, хорооны нийгмийн ажилтанд өгнө./Эх, олон

хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2.1-д зааснаар/

- өргөдөл;
- 1 хувь зураг;
- иргэний үнэмлэх, хуулбарын хамт;
- баг, хорооны Засаг даргын тодорхойлолт;
- жирэмсэн үедээ эмнэлгийн хяналтад орсон тухай өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчийн тодорхойлолт.

0-3 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХЭД АСАРСНЫ ТЭТГЭМЖ:

0-3 хүртэл насны хүүхдээ асарч байгаа эхэд хүүхдийн тооноос үл хамааран Засгийн газраас тогтоосон хэмжээгээр сар бүр 50,000 төгрөгийн тэтгэмжийг олгоно.

Хүүхэд асарсны тэтгэмж авч байх хугацаандаа эх нь жирэмсэн эхийн тэтгэмж авах эрх үүсвэл түүнд уг тэтгэмжийг давхар олгоно.

0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжид хамрагдах иргэн дараах бичиг баримтыг бүрдүүлэн сум, хорооны нийгмийн ажилтанд өгнө./Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2.2-т зааснаар/

- өргөдөл;
- 1 хувь зураг;
- иргэний үнэмлэх, хуулбарын хамт;
- хүүхэд эсэн мэнд бойжиж байгаа тухай өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчийн тодорхойлолт;
- хүүхдийн төрсний гэрчилгээ, хуулбарын хамт;
- Хөдөлмөрийн тухай хуулийн 106.1-д заасны дагуу хүүхэд асрах чөлөөтэй байгаа бол чөлөө олгосон тухай ажил олгогчийн тушаал, хуулбарын хамт;
- баг, хорооны Засаг даргын тодорхойлолт

ИХЭР ХҮҮХДИЙН ТЭТГЭМЖ:

Ихэр хүүхдийн тэтгэмж авах эхэд Засгийн газраас тогтоосон хэмжээгээр 2 ихэр хүүхэдтэй бол тус бүрт 1,0 сая төгрөг, 3 болон түүнээс дээш ихэр хүүхэдтэй бол хүүхэд тус бүрт 3,0 сая төгрөгийн тэтгэмжийг 1 удаа олгоно.

Ихэр хүүхдийн тэтгэмжид хамрагдах иргэн дараах бичиг баримтыг бүрдүүлэн сум, хорооны нийгмийн ажилтанд өгнө./Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2.3-т зааснаар/

- өргөдөл;
- иргэний үнэмлэх хуулбарын хамт, гадаадад оршин суугаа иргэний хувьд иргэний үнэмлэх, эсхүл нотариатаар батлуулсан хуулбар;
- хүүхдүүдийн төрсний гэрчилгээ, хуулбарын хамт;
- ихэр хүүхэд нь эсэн мэнд бойжиж байгаа тухай өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчийн тодорхойлолт;
- баг, хорооны Засаг даргын тодорхойлолт;
- гадаадад оршин суугаа иргэний хувьд тухайн газрын эмч, эмнэлгийн байгууллагын тодорхойлолт, Монгол улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын тодорхойлолт.

ГУРАВ БОЛОН ТҮҮНЭЭС ДЭЭШ ХҮҮХЭД ТӨРҮҮЛСЭН ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭХ, ЭЦГИЙН ТЭТГЭМЖ:

0-18 хүртэлх насны гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү хэмжээний тэтгэмжийг улирал бүр олгоно.

Гурав болон түүнээс дээш хүүхэд төрүүлсэн өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжид **хамрагдах иргэн дараах бичиг баримтыг бүрдүүлэн сум, хорооны нийгмийн ажилтанд өгнө./Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2.4-т зааснаар/**

- Өргөдөл;
- 1 хувь зураг;
- нас барсан эхнэр, эсхүл нөхрийн нас барсны гэрчилгээ, хуулбарын хамт;
- баг, хорооны Засаг даргын тодорхойлолт;
- хүүхдүүдийн төрсний гэрчилгээ, хуулбарын хамт /16 насанд хүрсэн бол иргэний үнэмлэх, хуулбарын хамт/;
- нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.8-д заасан өрх толгойлсон эх, эцэг /нөхөр, эхнэрийн аль нэг нь нас барсан, эсхүл сураггүй алга болсон нь шүүхээр тогтоогдсон, гэрлэлтээ цуцлуулсан, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх

хугацаанд, гэрлэж байгаагүй боловч төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэдтэй ганц бие эх, эцэг/-т тэтгэмж олгох талаар сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлөөс гаргасан шийдвэр.

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ НЬ ДАРААХ ТӨРЛҮҮДТЭЙ. ҮҮНД:

1. Асаргааны тэтгэмж
2. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэний тэтгэмж
3. Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж
4. Хүүхдийн мөнгөн тэтгэмж

АСАРГААНЫ ТЭТГЭМЖ

Асаргааны тэтгэмжийг дараах иргэнд олгоно. Сар бүр 70000 төгрөгийг сар бүрийн 15-аас харъяа банкнаас хүлээн авна. Асаргааны тэтгэмжийг хөдөлмөрийн насны иргэнээс гадна ахмад настан болон 16-гаас дээш насны хүүхдэд олгож болно. (МУЗГ-ын 2012 оны 185 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж олгох журам"-ын 4.6-д зааснаар) Асаргааны тэтгэмжийг асруулагч тус бүрээр тооцож олгоно. Нэг иргэн нэг хаяг дээр оршин суугаа 3-аас дээшгүй иргэнийг асарч болно. МУЗГ-ын 2012 оны 185 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж олгох журам"-ын 4.5-д зааснаар)

- Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа иргэн асаргааны тэтгэмжид хамрагдахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлж сум, хорооныхоо нийгмийн ажилтанд өгнө.

- Гэр бүлийн тухай хуулийн [\[5\]](#) 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие махбодын хохирол хүлээж хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа;

- Тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа;

- Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа иргэн

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ДЭМЖЛЭГ, ТУСЛАЛЦАА ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ӨРХИЙН ГИШҮҮН-ИРГЭНИЙ ТЭТГЭМЖ

Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэний тэтгэмжийг олгох тухай хуулийн заалт хэрэгжиж эхлээгүй байна.

ОНЦГОЙ ТОХИОЛДЛЫН БОЛОН АМЬЖИРГААГ ДЭМЖИХ МӨНГӨН ТЭТГЭМЖ

Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид дараах өрх, иргэн хамрагдана.

ТЭТГЭВЭР ТЭТГЭМЖ ТОГТООЛГОХ ӨРГӨДӨЛ ГАРГАХ, ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ

Тэтгэвэр, тэтгэмж тогтоолгон авахыг хүссэн иргэн холбогдох баримт бичгийг бүрдүүлж, өргөдлийн хамт сум, хорооны нийгмийн ажилтанд өгнө. Сум, хорооны нийгмийн ажилтан тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох өргөдлийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлүүлнэ.

ТЭТГЭВЭР ТЭТГЭМЖ ОЛГОХ ТАЛААР

- Нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага тэтгэвэр, тэтгэмжийг банкаар дамжуулан олгоно

- Тэтгэвэр, тэтгэмж авагч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрөө хүсэлт гаргавал улиралд олгох тэтгэвэр, тэтгэмжийг тухайн улирлын эхний сард бөөнөөр нь олгож болно

- Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрийн биеэр ирж тэтгэвэр, тэтгэмжээ авах боломжгүй иргэний тэтгэвэр, тэтгэмжийг түүний итгэмжлэгдсэн иргэнд, эсхүл нийгмийн халамжийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан гэрт нь хүргэж өгнө.

- 16 хүртэлх насны хүүхдэд олгох тэтгэвэр, тэтгэмжийг эцэг, эх, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нь олгоно.

- Иргэн хүсэлтээ гаргасан тохиолдолд нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага тэтгэвэр, тэтгэмжийг тухайн иргэний хадгаламжийн дансанд нь шилжүүлж болно.

ХҮҮХДИЙН МӨНГӨН ТЭТГЭМЖ

Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамрагдсан өрх, иргэний хүүхдийн мөнгийг банкинд хүсэлт гаргасан сараас тооцон сар бүр олгоно.

Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамрагдсан өрхийн 0-18 хүртэлх насны хүүхэд (цаашид “хүүхэд” гэх), эсхүл түүнийг төлөөлөх хууль ёсны эрх бүхий Монгол Улсын иргэнд олгоно.

Хүүхэд болон хүүхдийг төлөөлөн хүүхдийн мөнгөн тэтгэмж авах эх (эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, итгэмжлэгдсэн этгээд) нь үйлчлүүлэх арилжааны банкиг өөрөө сонгох эрхтэй.

Тухайн хүүхдэд хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох зөвхөн нэг банкиг сонгож, уг банкинд өөр эзэмшигч ашиглаж байгаагүй зөвхөн нэг данс нээлгэнэ.

Хүүхдийн эх /эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, итгэмжлэгдсэн этгээд\ эсхүл 16 насанд хүрсэн бол хүүхэд өөрөө хүүхдийн мөнгөн тэтгэмж авах хүсэлт гаргаж болно.

Иргэн сонгосон арилжааны банкинд өөрийн биеэр очиж хүүхдийн мөнгөн тэтгэмжээ авах хүсэлт гаргана.

Асран хамгаалагч /14 хүртэл насны хүүхдэд/, харгалзан дэмжигч /14-18 насны хүүхэд/-ийг Сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр тогтооно.

Итгэмжлэлийг нотариатчаас авна.

Иргэн хүүхдийн мөнгөн тэтгэмж авах хүсэлт гаргахдаа дор дурдсан баримт бичгийг бүрдүүлж банкны ажилтанд өгнө:

Хүүхдийг төлөөлөн мөнгө авах эх /эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, итгэмжлэгдсэн этгээд/-ийн иргэний цахим үнэмлэх

1. Хүүхдийн төрсний гэрчилгээ, 16 насанд хүрсэн бол иргэний цахим үнэмлэх

2. Хэрэв хүүхэд асрамжийн газарт байгаа бол тухайн асрамжийн газрын тодорхойлолт;

3. “Гэр бүлийн тухай” хуулийн 66.1-д заасны дагуу асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоогдсон бол сум, дүүргийн Засаг даргын шийдвэр, түүний хуулбар;

4. Гадаадад амьдарч байгаа Монгол Улсын иргэний хувьд Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрын тодорхойлолт, итгэмжлэл;

Дээрх баримт бичгийг банкны ажилтан хүлээн авч өргөдлийн маягт бөглүүлэн, иргэнээр гарын үсэг зуруулж баталгаажуулан авна.

Иргэн хүүхдийн мөнгөн тэтгэмж авах дансыг хүүхэд тус бүрээр нээлгэнэ.

Асрамжийн газарт асруулж байгаа хүүхдийн мөнгийг тухайн асрамжийн газар уг хүүхдийн нэр дээр хадгаламжийн данс нээлгэж банкинд хадгалуулна. Хадгаламжийн дэвтрийг тухайн асрамжийн газрын харьяа аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага хадгалж, хүүхдийг 16 нас хүрч иргэний үнэмлэх авсны дараа өөрт нь хүлээлгэн өгнө.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа анги, байгууллагад ял эдэлж байгаа болон цагдан хоригдож байгаа хүүхдийн мөнгийг тухайн хүүхдийн нэр дээр данс нээлгэж банкинд хадгалуулна. Хадгаламжийн дэвтрийг тухайн хорих газрын харьяа аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага хадгалж, хүүхдийг суллагдсаны дараа өөрт нь хүлээлгэн өгнө.

Хоёрдмол харьяалалтай болсон иргэний хүүхдэд хүүхдийн мөнгө олгохгүй.

Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараахь тохиолдолд хүүхдийн мөнгө олгохыг зогсоох шийдвэр гаргана.

Үүнд:

1. Хүүхэд 18 нас хүрсэн;
2. Хүүхэд нас барсан;
3. Монгол Улсын харьяатаас гарсан;

Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараахь тохиолдолд хүүхдийн мөнгө олгохыг түр зогсоох шийдвэр гаргана Үүнд:

1. Хуурамч баримт бичиг бүрдүүлэх, худал мэдээлэл өгөх, хүүхдийн мөнгө авахаар нэгээс дээш банкинд санаатайгаар давхар данс нээлгэх зэргээр хүүхдийн мөнгө авсан нь тогтоогдсон;
2. Регистрийн дугаар давхардах зэрэг өөр бусад шалтгаанаар хүүхдийн мөнгө илүү олгогдсон;
3. Тухайн өрхийн ам бүлийн тоо гурав болон түүнээс дээш гишүүнээр өөрчлөгдсөн;
4. Хүүхдийн мөнгө авч байгаа өрх нь сум, дүүрэг, аймаг хооронд шилжилт хөдөлгөөн хийсэн;

Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамрагдаагүй өрхийн хүүхдэд олгохгүй.

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР

Нийгмийн халамжийн тэтгэврийг нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасны дагуу тэтгэвэр авах эрх үүсээгүй дараах иргэнд сар бүр олгоно. Нийгмийн халамжийн тэтгэвэрт дараах иргэд хамаарна.

1. 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй,
2. 16 насанд хүрсэн одой иргэн,
3. Хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн,
4. Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагдана.

60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагдахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлж сум, хорооныхоо нийгмийн ажилтанд өгнө.

- Өргөдөл (маягтын дагуу)
- 2 хувь зураг

- Иргэний үнэмлэх, хуулбарын хамт

- Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс (сумын нийгмийн даатгалын байцаагч)-ийн тодорхойлолт

Ахмад настан нийгмийн халамжийн тэтгэвэр 155000 төгрөгийг сар бүрийн 15-аас тухайн сар дуустал хугацаанд харъяа банкнаас тэтгэврийн дэвтэр, иргэний үнэмлэхтэйгээ очиж авна.

16 насанд хүрсэн одой иргэн нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагдахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлж сум, хорооныхоо нийгмийн ажилтанд өгнө.

- Өргөдөл (маягтын дагуу) тодорхойлолт

- Сум, хорооны Засаг даргын тодорхойлолт

- 2 хувь зураг

- Иргэний үнэмлэх, хуулбарын хамт

- Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс (сумын нийгмийн даатгалын байцаагч)-ийн тодорхойлолт

- Одой болохыг тогтоосон Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр

16 насанд хүрсэн одой иргэн нийгмийн халамжийн тэтгэвэр 155000 төгрөгийг сар бүрийн 15-аас тухайн сар дуустал хугацаанд харъяа банкнаас тэтгэврийн дэвтэр, иргэний үнэмлэхтэйгээ очиж авна.

Хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагдахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлж сум, хорооныхоо нийгмийн ажилтанд өгнө.

- Өргөдөл (маягтын дагуу);

- 2 хувь зураг;

- Иргэний үнэмлэх, хуулбарын хамт; 6.1.7. Нийгмийн халамжийн тухай хуулийн 12.1.4-т заасан хүүхдийн тухайд тэжээгчийн нас барсны гэрчилгээ, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн иргэний үнэмлэх, тэдгээрийн хуулбар ;

- Сум, хорооны Засаг даргын тодорхойлолт;

- 16 нас хүрээд нийгмийн халамжийн тэтгэвэр тогтоолгож байгаа иргэнээс бусад иргэнд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс (сумын нийгмийн даатгалын байцаагч)-ийн тодорхойлолт;

- Сум хорооны амьжиргаагдэмжих зөвлөлийн шийдвэр, Аймаг дүүргийн засаг даргын захирамж,

Хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийгмийн халамжийн тэтгэвэр 155000 төгрөгийг сар бүрийн 15-аас тухайн сар дуустал хугацаанд харъяа банкнаас тэтгэврийн дэвтэр, иргэний үнэмлэхтэйгээ очиж авна.

Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагдахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлж сум, хорооныхоо нийгмийн ажилтанд өгнө.

- Өргөдөл (маягтын дагуу)

- 2 хувь зураг;

- Иргэний үнэмлэх, хуулбарын хамт;

- Тэжээгчийн нас барсны гэрчилгээ, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн иргэний үнэмлэх, тэдгээрийн хуулбар ;

- 18 хүртэлх насны хүүхдийн төрсний гэрчилгээ, эх (эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч)-ийн иргэний үнэмлэх, тэдгээрийн хуулбар.

- Сум, хорооны Засаг даргын тодорхойлолт;

- 16 нас хүрээд нийгмийн халамжийн тэтгэвэр тогтоолгож байгаа иргэнээс бусад иргэнд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх

үүсээгүй тухай аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс (сумын нийгмийн даатгалын байцаагч)-ийн тодорхойлолт;

- Сум хорооны амьжиргаагдэмжих зөвлөлийн шийдвэр, Аймаг дүүргийн засаг даргын захирамж,

Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд нийгмийн халамжийн тэтгэвэр 1-2 хүүхдэд 155000, 3-4 хүүхдэд 232500, 5-аас дээш хүүхдэд 310000 төгрөгийг сар бүрийн 15-аас тухайн сар дуустал хугацаанд харъяа банкнаас тэтгэврийн дэвтэр, иргэний үнэмлэхтэйгээ очиж авна.

ТЭТГЭВЭР ТЭТГЭМЖ ТОГТООЛГОХ ӨРГӨДӨЛ ГАРГАХ, ШИЙДВЭРЛЭХ ХУГАЦАА

Тэтгэвэр, тэтгэмж тогтоолгон авахыг хүссэн иргэн холбогдох баримт бичгийг бүрдүүлж, өргөдлийн хамт сум, хорооны нийгмийн ажилтанд өгнө. Сум, хорооны нийгмийн ажилтан тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох өргөдлийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлүүлнэ.

ТЭТГЭВЭР ТЭТГЭМЖ ОЛГОХ ТАЛААР

- Нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага тэтгэвэр, тэтгэмжийг банкаар дамжуулан олгоно

- Тэтгэвэр, тэтгэмж авагч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрөө хүсэлт гаргавал улиралд олгох тэтгэвэр, тэтгэмжийг тухайн улирлын эхний сард бөөнөөр нь олгож болно

- Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрийн биеэр ирж тэтгэвэр, тэтгэмжээ авах боломжгүй иргэний тэтгэвэр, тэтгэмжийг түүний итгэмжлэгдсэн иргэнд, эсхүл нийгмийн халамжийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан гэрт нь хүргэж өгнө.

- 16 хүртэлх насны хүүхдэд олгох тэтгэвэр, тэтгэмжийг эцэг, эх, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нь олгоно.

- Иргэн хүсэлтээ гаргасан тохиолдолд нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага тэтгэвэр, тэтгэмжийг тухайн иргэний хадгаламжийн дансанд нь шилжүүлж болно.



ДААТГУУЛАГЧИЙН ТАХИР ДУТУУГИЙН ТЭТГЭВЭР АВАХ ЭРХ:

Шимтгэл төлвөл зохих хугацаа:

- Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20-иос доошгүй жил төлсөн байх;
- Эсхүл тахир дутуу болохын өмнөх 5 жилийн 3 жилд шимтгэл төлсөн байх;
- Хөдөлмөрийн чадвараа 50-иас доошгүй хувиар алдсан даатгуулагч тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгох эрхтэй.

Нийтдээ 3-аас доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн, хөдөлмөрийн чадвараа 50-иас доошгүй хувиар алдсан даатгуулагч тахир дутуугийн тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож болно.

Хөдөлмөрийн чадвар алдсаныг тогтоолгох:

Аймаг, дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, шалтгаан, хугацааг тогтооно.

Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтыг 70 ба түүнээс дээш хувиар тогтоосон бол хөдөлмөрийн чадвараа бүрэн, 50-69 хувиар тогтоосон бол хөдөлмөрийн чадвараа хагас (хэсэгчилсэн) алдсан гэж үзнэ.

Тахир дутуугийн тэтгэврийг яаж тооцох вэ?

Тахир дутуугийн бүрэн тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх аль дуртай дараалсан 7 жилийн буюу 84 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас 45 хувиар, 20-иос илүү ажиллаж шимтгэл төлсөн жил тутамд 1.5 хувиар, сар тутамд 0.125 хувиар бодож нэмэгдэл олгоно.

Даатгуулагч хөдөлмөрийн чадвараа хагас алдсан тохиолдолд дээр дурдсан хэмжээнээс хөдөлмөрийн чадвар алдсан хувь хэмжээгээр тэтгэврийг нь бодож тогтооно.

Жишээ: Даатгуулагч ердийн өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа 55 хувиар алдсан, нийтдээ 20 жил шимтгэл төлж ажилласан, дундаж цалин нь 1 500 000 төгрөг гэвэл:

а) Өндөр насны тэтгэвэр бодох хувьд ногдох хэсэг: $1,500,000\text{₮} * 45\% = 675,000\text{₮}$

б) Сард олговол зохих тахир дутуугийн тэтгэвэр: $675,000\text{₮} * 55\%(\text{ХЧАлдалтын хувь}) = 371,250$

в) Засгийн газрын 2022 оны 63 дугаар тогтоолоор бүрэн тэтгэврийн доод хэмжээг

500 000 төгрөгөөр тогтоосон тул сард **500 000** төгрөгийн тэтгэвэр олгоно.

Тахир дутуугийн тэтгэврийг ямар хугацаанд олгох вэ?

Тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа алдсан өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, хэрэв тэтгэвэр авагч нь нас барвал нас барсны дараагийн сарыг дуусах хүртэлх хугацаанд олгоно.

Тахир дутуугийн тэтгэвэр тогтооход бүрдүүлэх баримт бичиг:

- Тэтгэвэр тогтоолгохыг хүссэн өргөдөл;
- Нийгмийн даатгалын дэвтэр (2021 оноос өмнөх);
- Хөдөлмөрийн дэвтэр (1995 оноос өмнөх);
- Хөдөлмөрийн хөлсний тодорхойлолт (1995 оноос өмнө ажилласан хугацаанд авсан хөдөлмөрийн хөлснөөс тэтгэвэр тогтоолгох бол);
- Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоос хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоосон акт;
- Хөдөлмөрийн болон эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн баталсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн акт”.

Санамж: Тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан даатгуулагч (иргэн) Хөдөлмөрийн дэвтэр (1995 оноос өмнөх), Шүүхийн шийдвэр, Архивын лавлагаа, Гомдлын шаардлагын зөвлөлийн тогтоол зэрэг баримт бичгийг заавал үндсэн баримт бичгээр буюу эхээр нь ирүүлнэ.

1. ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭР:

“Өндөр насны тэтгэвэр” гэдэг нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь нийгмийн батлагааг нь хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Өндөр насны тэтгэвэр авах эрх:

–Шимтгэл төлсөн байвал зохих хугацаа: **2022 онд – 21 жил 3 сар ба түүнээс дээш**

(цаашид жил бүр 3 сараар нэмэгдэж 2037 онд 25 жил болно)

-Нас: **Өөрөө хүсвэл эрэгтэй 60 нас, эмэгтэй 55 нас**

Эсхүл:

–Шимтгэл төлсөн байвал зохих хугацаа: **10-20 жил**

-Нас: **Төрсөн ондоо харгалзах насанд хүрсэн байна.**

Хэрэв даатгуулагч тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих дээрх болзлыг хангаагүй тохиолдолд өндөр насны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгоно:

-*Шимтгэл төлсөн байвал зохих хугацаа: 10-19 жил*

-*Нас: Төрсөн ондоо харгалзах насанд хүрсэн байна.*

3. ХӨДӨЛМӨРИЙН ХЭВИЙН БУС НӨХЦӨЛИЙН ТЭТГЭВЭР



Даатгуулагч нь нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс дор дурдсан хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж шимтгэл төлсөн тохиолдолд өөрөө хүсвэл тухайн насанд хүрээд тэтгэвэр тогтоолгох эрхтэй. Үүнд:

Хөдөлмөрийн нөхцөл	Хүйс	Нас	Тухайн хөдөлмөрийн нөхцөлд ажиллаж, шимтгэл төлсөн байвал зохих хугацаа
Газрын дор нөхцөл	Эрэгтэй	50	10 жил
Хөдөлмөрийн хортой, халуун нөхцөл	Эрэгтэй	50	10 жил
	Эмэгтэй	45	7 жил 6 сар
Хөдөлмөрийн хүнд нөхцөл	Эрэгтэй	55	12 жил 6 сар
	Эмэгтэй	50	10 жил

МАЛЧИН ДААТГУУЛАГЧИЙН ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭР



Малчин гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд зааснаар мал аж ахуй эрхэлж үндсэн орлогоо олдог иргэнийг ойлгоно. Түүнчлэн аж ахуй нэгж, байгууллага, иргэнтэй хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээний үндсэн дээр мал маллаж байсан малчин, саальчин, тугалчин, тууварчин (1990 оноос өмнөх тууварчинг хамааруулна) Монгол Улсын иргэнийг малчинд хамааруулна.

Доор дурдсан нөхцөлийг хангасан малчин тэтгэвэр тогтоолгох эрхтэй. Үүнд:

- Нийтдээ 20-оос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн, үүнээс 15 жил малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 55 нас хүрсэн эрэгтэй.
- Нийтдээ 20-оос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн, үүнээс 12 жил 6 сар малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 50 нас хүрсэн эмэгтэй.

Малчнаар ажилласанд хамаарахгүй хугацаа:

- Ерөнхий боловсролын сургууль болон их, дээд сургууль, коллежийн өдрийн ангид суралцсан хугацаа;
- Цэргийн алба хаасан хугацаа;
- Малчнаас өөр ажил, хөдөлмөр эрхэлсэн хугацаа;
- Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсаны улмаас нийгмийн даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр, нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр авч байсан хугацаа.

Өндөр насны тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх баримт бичиг:

- Тэтгэвэр тогтоолгохыг хүссэн өргөдөл;
- Нийгмийн даатгалын дэвтэр (2021 оноос өмнөх);
- Хөдөлмөрийн дэвтэр (1995 оноос өмнөх);

- Хөдөлмөрийн хөлсний тодорхойлолт (1995 оноос өмнө ажилласан хугацаанд авсан хөдөлмөрийн хөлснөөс тэтгэвэр тогтоолгох бол)

- Иргэний үнэмлэхийн хуулбар, эсхүл лавлагаа;

- Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн дагуу ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлээ нөхөн тооцуулсан тухай нийгмийн даатгалын байгууллагаас олгосон баримт, лавлагаа;

- Тухайн үед оршин сууж байсан тухай баг, хорооны Засаг даргын тодорхойлолт;

- Малчнаар ажилд томилсон, чөлөөлсөн тухай тушаал, эсхүл хөлсөөр ажиллах гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, эсхүл тэдгээртэй адилтгах гэрээ;

- 1995 оноос хойш малчнаар ажилласныг нотлох “Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллого”-ын бүртгэл, лавлагаа.

Үндэсний статистикийн хорооноос баталсан “Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн ... оны тооллого”-ын жил бүрийн бүртгэл буюу “А” дансны лавлагаа:

- Даатгуулагч 1995 оноос өмнөх хугацаанд мал маллаж байсан тохиолдолд “А” дансны лавлагаа шаардлагагүй;

- Даатгуулагч 1995 оноос хойш мал маллаж байгаа нь “А” дансаар нотлогдохгүй тохиолдолд түүний малчнаар ажиллаж байсан хугацааг тухайн сум, дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулсан “Даатгуулагчийн малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөл”-ийн тогтоолыг үндэслэнэ.

Өндөр насны тэтгэвэр олгох хугацаа:

Өндөр насны тэтгэврийг даатгуулагч өргөдлөө тэтгэвэр тогтоолгох насанд хүрэхээс өмнө гаргасан бол уг насанд хүрсэн өдрөөс, эсхүл тэтгэвэр тогтоолгох насанд хүрснээс хойш гаргасан бол өргөдлийг хүлээн авсан өдрөөс эхлэн, нас барсны дараагийн сар дуустал хугацаанд олгоно.

Шимтгэл төлвөл зохих хугацаа:


Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг нийтдээ 36 сараас доошгүй хугацаанд төлсөн байх. Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан бол шимтгэл төлсөн хугацааг харгалзахгүй.

Оршуулгын тэтгэмжийн хэмжээ:

Оршуулгын тэтгэмжийн хэмжээ Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны 16 дугаар тогтоолоор баталсны дагуу 1 000 000 төгрөг байна.

Бүрдүүлэх баримт бичиг:

- Өргөдөл
- Нас барсан даатгуулагчийн хөдөлмөрийн дэвтэр
- Нас барсан даатгуулагчийн нийгмийн даатгалын дэвтэр
- Нас барсны гэрчилгээ



Шимтгэл төлсөн байвал зохих хугацаа:

Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг жирэмсний чөлөө авахаас өмнө 12 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 6 сард нь тасралтгүй төлсөн даатгуулагч эх жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрхтэй.

Ажил хөдөлмөр эрхэлж байсан буюу албан журмын даатгуулагч эхэд хуульд заасны дагуу хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацаандаа дахин хүүхэд **төрүүлэх бүрт** жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгоно.

Тэтгэмжийн даатгалын шимтгэл төлөх хугацааг хангасан даатгуулагч эх, хүүхдээ 196-гаас доошгүй хоног тээгээд дутуу төрүүлсэн буюу үр хөндүүлсэн, жирэмслэлтийг эмнэлгийн аргаар тасалсан, мөн 196 хоног тээгээгүй боловч амьдрах чадвартай хүүхэд төрүүлсэн бол жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрхтэй.

Жирэмсний болон амаржсаны тэтгэмж бодох хувь хэмжээ:

Даатгуулагчид жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг 4 сарын хугацаанд ажлын өдрөөр тооцож сүүлийн 12 сарын дундаж хөдөлмөрийн хөлс, орлогоос дор дурдсан хувь хэмжээгээр тооцно:

Нийгмийн даатгалын хэлбэр	Тэтгэмж бодох хувь
----------------------------------	---------------------------

Албан даатгуулагч	журмын	100 %
Сайн даатгуулагч	дурын	

Жишээ: Даатгуулагч эх 6 жил тасралтгүй тэтгэмжийн даатгалын шимтгэл төлж ажилласан, түүний сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлсний дундаж 1.500.000 төгрөг, түүнд жирэмсний эмнэлгийн хуудсыг 2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс хуанлийн 60 хоногоор бичиж олгосон гэвэл:

а) Сарын ажлын өдрийн дундаж хоног: 21.2 хоног

б) Нэг өдөрт ногдох хөдөлмөрийн хөлс, орлого: 1,500,000₮ : 21,2 хоног = 70,755₮

в) Тэтгэмж олгох хоног: 43 өдөр (эмнэлгийн хуудсанд бичигдсэн хугацаан дахь ажлын өдрөөр тооцно)

г) Олговол зохих тэтгэмж: 70,755₮ * 43 өдөр = 3,042,453₮

Хэрэв даатгуулагч эх ихэр хүүхэд төрүүлсэн бол тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас 100 хувиар тооцож 4 сар 20 хоногийн хугацаанд жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг олгоно.

Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах хүсэлт илгээх:

Даатгуулагч Та жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах хүсэлтээ <https://daatguulagch.ndaatgal.mn/> цахим хаягаар нийгмийн даатгалын байгууллагад илгээж болно.

Бүрдүүлэх баримт бичиг:

- Эмнэлгийн хуудас (хэрэв эмнэлгийн хуудсыг цахимаар бичүүлсэн тохиолдолд Даатгуулагчийн веб (daatguulagch.ndaatgal.mn)-ийн тусламжтайгаар тэтгэмж авах хүсэлтээ илгээнэ).

Шимтгэл төлвөл зохих хугацаа:

Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдахаас өмнө 3 ба түүнээс дээш сарын хугацаагаар төлсөн даатгуулагч хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж авах эрхтэй.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацааг харгалзан түүний сүүлийн бүтэн ажилласан 3 сарын хөдөлмөрийн хөлснөөс доор дурдсан хувь хэмжээгээр бодно:

Шимтгэл төлсөн хугацаа	Шимтгэл бодох хувь
5 хүртэл жил	50%
5-14 жил	55%
15 ба дээш жил	75%

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох хугацаа:



- Хөдөлмөрийн чадвар түр хугацаагаар алдсан ажлын эхний 5 өдрийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ажил олгогчоос, 6 дахь өдрөөс эхлэн чадвар нь сэргээгдэх, эсхүл тахир дутуугийн тэтгэвэр авах эрх үүсэх хүртэл хугацааны тэтгэмжийг тэтгэмжийн даатгалын сангаас тус тус олгоно.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах хүсэлт илгээх:

Даатгуулагч Та хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах хүсэлтээ <https://daatguulagch.ndaatgal.mn/> цахим хаягаар нийгмийн даатгалын байгууллагад илгээж болно.

Тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичиг:

- Эмнэлгийн хуудас (албан журмын даатгуулагч эмнэлгийн хуудсыг цахимаар бичүүлсэн тохиолдолд ажил олгогчоос нийгмийн даатгалын байгууллага руу илгээнэ).

Сайн дурын даатгуулагчийн хувьд:

- Эмнэлгийн хуудсыг харьяалах Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлж, тэтгэмж авах хүсэлтээ гаргана;

- Эмнэлгийн хуудсыг цахимаар бичүүлсэн тохиолдолд Даатгуулагчийн веб (ndaatgal.mn)-ийн тусламжтайгаар тэтгэмж авах хүсэлтээ илгээнэ.

Ажилгүйдлийн даатгалын сангаас даатгуулагчид дор дурдсан тэтгэмж, зардлыг олгоно. Үүнд:



Ажилгүйдлийн тэтгэмж

Мэргэжил олгох, давтан сургалтын зардал

Ажилгүйдлийн тэтгэмж авах эрх:

Даатгуулагч нь дараах болзлыг хангасан тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмж авах эрх анх үүснэ.

- Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг ажлаас чөлөөлсөн тухай шийдвэр гарахаас өмнө 24 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 9 сард нь тасралтгүй төлсөн.

Урьд нь ажилгүйдлийн тэтгэмж авсан даатгуулагч ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг 12 сараас доошгүй хугацаагаар төлсөн нөхцөлд тэтгэмж авах эрх нь дахин үүснэ.

Ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ:

Даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг шимтгэл төлсөн сүүлийн 3 сарын дундаж хөдөлмөрийн хөлс, орлогоос дараах хувь, хэмжээгээр бодож олгоно:

Шимтгэл төлсөн хугацаа	Тэтгэмж бодох хувь
5 хүртэл жил	45%
5-10 хүртэл жил	50%
10-15 хүртэл жил	60%
15 ба түүнээс дээш жил	70%

Ажилгүйдлийн тэтгэмж олгох олгох хугацаа:

Даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлсний дараагийн өдрөөс эхлэн ажлын 76 өдрийн хугацаанд олгоно.

Ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлт илгээх:

Даатгуулагч Та ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтээ <https://daatguulagch.ndaatgal.mn/> цахим хаягаар нийгмийн даатгалын байгууллагад илгээж болно.

Бүрдүүлэх бичиг баримт:

- Тэтгэмж олгохыг хүссэн өргөдөл;
- Ажлаас чөлөөлсөн тухай шийдвэр;
- Хөдөлмөрийн байгууллагад бүртгүүлсэн тухай тодорхойлолт.

• САЙН ДУРЫН ДААТГАЛ

Ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ байгуулан, албан журмаар даатгуулснаас бусад хөдөлмөрийн насны бүх иргэн нийгмийн даатгалд сайн дурын хэлбэрээр хамрагдах боломжтой. Тухайлбал:

- Хувиараа хөдөлмөр эрхлэгч
- Малчин
- Газар тариалан эрхлэгч
- Бичил уурхай эрхлэгч
- Чөлөөт уран бүтээлч
- Тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэн
- Гадаад улсад ажиллаж, амьдарч буй иргэн
- Оюутан суралцагч
- Хөдөлмөрийн гэрээ бүхий туслах малчин
- Хөдөлмөрийн гэрээ бүхий гэрийн үйлчилгээний ажилтан
- Бусад иргэн

0-3 насны хүүхдээ асрах чөлөөтэй байгаа эхчүүдийн сайн дурын даатгалын шимтгэл төлөлт:

- Албан журмын буюу ажил хөдөлмөр эрхэлж байсан эхийн төлөх шимтгэлийг ажил олгогч хариуцан төлнө.
- Хүүхдээ 3 нас хүртэл асарч байгаа сайн дураар даатгуулагч эх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (420 000 төгрөг)-ний 12.5 хувьд ногдох хэсгийн 50.0 хувийг өөрөө хариуцан төлсөн тохиолдолд үлдсэн 50.0 хувийг тэтгэмжийн даатгалын сангаас эсхүл улсын төсвөөс тус тус тооцон шимтгэл төлнө.

Жишээ нь: Даатгуулагчийн сард төлөх шимтгэл $420\,000 \times 12.5\% = 52\,500$ төгрөг

Үүнээс: 50% – 26 250 төгрөг (Даатгуулагч эх өөрөө төлнө)

50% – 26 250 төгрөг (Тэтгэмжийн даатгалын сангаас болон улсын төсвөөс хариуцан төлнө)

Сайн дурын даатгалын гэрээ байгуулах:

- Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах иргэд нийгмийн даатгалын байгууллага (нийгмийн даатгалын байцаагч эсвэл “Нийгмийн даатгал” аппликейшн)-тай тохиролцон “Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай” гэрээ байгуулах бөгөөд гэрээнд шимтгэл тооцох сарын орлого, шимтгэл төлөх хугацаагаа тодорхой тусгаж өгнө.
- Шимтгэл тооцох сарын орлогын доод хэмжээ нь Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос тогтоосон тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байна.
- Шимтгэл тооцох сарын орлогын дээд хэмжээ тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна.

Сайн дурын даатгалын шимтэл төлөх:

Сайн дураар даатгуулагч нь нийгмийн даатгалын байгууллагатай байгуулсан гэрээнд заасан хугацаанд төлбөл зохих шимтгэлээ доор дурдсан хэлбэрээр төлнө. Үүнд:

- “Нийгмийн даатгал” аппликейшн;
- Даатгуулагчид зориулсан веб програм;
- QR код эсхүл Орау;
- SENDLY ашиглан;
- Өөрийн үйлчлүүлдэг банкны аппликейшн;

- Банкны тооцооны салбарт очих гэх мэт.

Сайн дурын даатгалын гэрээ цуцлах:

Дараах тохиолдолд нийгмийн даатгалын байгууллагатай байгуулсан гэрээгээ цуцална.

- Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн эсхүл ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллах болсон;
- Тэтгэвэр тогтоолгосон;
- Нас барсан.

Сайн дураар даатгуулагчийн тэтгэвэр, тэтгэмж , төлбөр авах эрх:

Сайн дураар даатгуулагч хуульд заасан болзол, нөхцөлийг хангасан тохиолдолд дараах тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг авах эрхтэй.

Тэтгэврийн даатгалын сангаас:

- - Өндөр насны тэтгэвэр
 - Тахир дутуугийн тэтгэвэр
 - Тэжээгчээ алдсаны тэтгэвэр

Тэтгэмжийн даатгалын сангаас:

- - Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж
 - Жирэмсний болон амаржсаны тэтгэмж
 - Оршуулгын тэтгэмж

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас:

- - Тахир дутуугийн тэтгэвэр
 - Тэжээгчээ алдсаны тэтгэвэр
 - Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж
 - Хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр
 - Тэтгэврийн даатгалын шимтгэл
 - Рашаан болон мэргэжлээс шалтгаалсан өвчтөний сувилалд ирэх, очих унааны зардал

▪ Мэргэжлээс шалтгаалсан өвчтөний сувиллын тусламж, үйлчилгээний зардал

Сайн дураар даатгуулагчийн хүлээх хариуцлага:

Сайн дураар даатгуулагч нь сард төлбөл зохих шимтгэлээ нийгмийн даатгалын байгууллагатай байгуулсан гэрээнд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд дутуу төлөгдсөн буюу хугацаандаа төлөгдөөгүй шимтгэлийн дүнгээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0.3 хувиар тооцож алданги төлнө. Энэхүү алдангийн хэмжээ нь төлбөл зохих шимтгэлийн 50 хувиас хэтрэхгүй байна.

Бүрдүүлэх бичиг баримт:

- Өргөдөл;
- Нийгмийн даатгалын дэвтэр (2021 оноос өмнөх);
- Хөдөлмөрийн дэвтэр (1995 оноос өмнөх).

"НИЙГМИЙН ДААТГАЛ" АППЛИКЭЙШН

Даатгуулагчид зориулсан “Нийгмийн даатгал” аппликэйшнийг 2018 оноос эхлэн нэвтрүүлсэн бөгөөд даатгуулагч Та энэхүү аппликэйшнийг ашиглан өөрийн:

- Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээллээ харах, тодорхойлолт авах;
- Нийгмийн даатгалын сангаас авсан тэтгэвэр, тэтгэмжийн мэдээлэл авах;
- Нэрийн дансны орлогын мэдээлэл харах;
- Сайн дурын даатгалын гэрээ байгуулах, гэрээгээ сунгах, шимтгэлээ төлөх;
- Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаар мэдээлэл авах боломжтой.



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ГАР УТАСНААСАА

Нийгмийн даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг авахыг хүссэн хүн бүр iOS болон Android үйлдлийн системтэй гар утсаа ашиглан, хүссэн газраасаа бүртгүүлж, нийгмийн даатгалын үйлчилгээг авах боломжтой.



1. ТӨРСНИЙ БҮРТГЭЛ

Эцэг, эх, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, эсхүл эрх бүхий байгууллагын төлөөлөгч хүүхэд төрсөн өдрөөс хойш 30 хоногийн дотор дараах баримт бичгийг бүрдүүлж, төрсний бүртгэлд бүртгүүлнэ.

- Эцэг, эхийн иргэний үнэмлэх
- Хүүхэд төрсөн тухай эмнэлгийн байгууллагын магадлагаа
- Эцэг, эхийн гэрлэлтийн гэрчилгээ
- Гэрлэлтээ бүртгүүлээгүй эцэг, эх хүүхдээ эцгийн овог, нэрээр бүртгүүлэх хүсэлтэй бол тус тусдаа өргөдөл гаргана. Эцэг, эхийн хэн нэг нь ирэх боломжгүй бол өргөдлөө нотариатаар гэрчлүүлнэ.
- Эцэг, эх нь хэн болох нь тогтоогдоогүй хүүхдийг асрамжлан авах хүсэлтэй иргэн, эсхүл хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагын төлөөлөгч тухайн хүүхэд олдсон өдрөөс хойш 2 хоногийн дотор цагдаагийн байгууллагад тэмдэглүүлж, дараах баримт бичгийг бүрдүүлж хүүхдийг төрсний бүртгэлд бүртгүүлнэ.

2. ГЭРЛЭСНИЙ БҮРТГЭЛ

Гэрлэхийг хүсэгчид дараах баримт бичгийг бүрдүүлж, гэрлэсний бүртгэлд өөрийн биеэр бүртгүүлнэ.

- Тус тусдаа гаргасан өргөдөл
- Гэрлэхийг хүсэгчдийн иргэний үнэмлэх
- Гэрлэхийг хүсэгчдийн эрүүл мэндийн шинжилгээний бичиг /Дох, сэтгэц, сүрьеэ/
- Монгол Улсын иргэн гадаадын иргэнтэй, эсхүл Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суугаа гадаадын иргэд тус улсын нутаг дэвсгэр дээр гэрлэсний бүртгэлд бүртгүүлэх бол тухайн гадаадын иргэний харьяалсан улсын эрх бүхий байгууллага, эсхүл тухайн улсыг төлөөлөн ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газраас олгосон гэрлэлтийн байдлыг тусгасан баримт бичиг
- Гадаад улсын хууль тогтоомжийн дагуу гэрлэлтээ бүртгүүлсэн Монгол Улсын иргэн гэрлэсний бүртгэлд бүртгүүлэх 1,2-т заасан баримт бичигт тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон гэрлэснийг нотолсон баримт бичгийг хавсаргана

3. ГЭРЛЭЛТ ДУУСГАВАР БОЛСНЫ БҮРТГЭЛ

а/Гэрлэлтээ захиргааны журмаар цуцлуулах

Гэрлэлтээ захиргааны журмаар цуцлуулахыг харилцан зөвшөөрсөн иргэн дараах баримт бичгийг бүрдүүлж, гэрлэлт дуусгавар болсны бүртгэлд өөрийн биеэр бүртгүүлнэ.

Бүрдүүлэх материалын жагсаалт

- Тус тусдаа гаргасан өргөдөл
- иргэний үнэмлэх, эсхүл гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, эсхүл паспортыг орлох баримт бичиг
- Гэрлэлтийн гэрчилгээ
- 18-аас доош насны хүүхэдгүй тухай оршин суугаа засаг даргын тодорхойлолт

б/Гэрлэлтээ шүүхийн журмаар цуцлуулах

Гэрлэлтээ шүүхийн журмаар цуцлуулсан иргэн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор дараах баримт бичгийг бүрдүүлж, иргэний улсын бүртгэлд бүртгүүлнэ.

Бүрдүүлэх материалын жагсаалт

- Иргэний үнэмлэх
- Гэрлэлт цуцласан тухай шүүхийн шийдвэр
- Гэрлэлтийн гэрчилгээ
- Гэрлэгчид Монгол Улсын иргэн, эсхүл гэрлэгчдийн хэн нэг нь гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн бол тэдгээр нь гадаад улсын хууль тогтоомжийн дагуу гэрлэлтээ цуцлуулсан нь Монгол Улсын хууль тогтоомжид харшлахгүй бол тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон баримт бичгийг үндэслэн гэрлэлт дуусгавар болсныг иргэний улсын бүртгэлд бүртгүүлж болно

5. ҮРЧИЛСНИЙ БҮРТГЭЛ

Хүүхэд үрчлэн авахыг хүсэгч дараах баримт бичгийг бүрдүүлж, хүүхдийн оршин суугаа газрын сум, дүүргийн Засаг даргад өөрийн биеэр хандана.

Бүрдүүлэх материалын жагсаалт

- Өргөдөл
- Хүүхдээ үрчлүүлэх тухай эцэг, эхийн зөвшөөрөл

Үрчлэн авагч болон үрчлүүлж байгаа эцэг, эх, эсхүл асран хамгаалагч, эсхүл харгалзан дэмжигчийн иргэний үнэмлэх

- Гэрлэсэн бол гэрлэлтийн гэрчилгээ

НАС БАРСНЫ БҮРТГЭЛ

Иргэний нас барсныг нас барагчийн 18 нас хүрсэн гэр бүлийн гишүүн, эсхүл эцэг, эх, эсхүл төрөл садангийн хүний аль нэг нь нас барагчийн иргэний үнэмлэх болон доор дурдсан баримт бичгийн аль тохирохыг бүрдүүлж улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ.

Бүрдүүлэх материалын жагсаалт

- Иргэний нас барсан тухай эмнэлгийн магадлагаа
- Иргэнийг нас барсан гэж зарласан шүүхийн шийдвэр
- Нас барсан шалтгааны тухай шүүх эмнэлгийн дүгнэлт
- Гамшгийн улмаас хүний амь нас эрсэдсэн бол Засгийн газраас байгуулсан онцгой комиссын шийдвэр